



**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 1/127

Улаанбаатар хот

Авлигын эсрэг төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12, 6.1.14 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 8.11.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн 2026 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Компанийн 2026 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг хэлтэс, албаны дарга болон компанийн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/68 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ГАНЧУЛУУН

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан
 түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн
 01/127 дугаар тушаалын хавсралт



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	5	6
1	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах;	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, иргэд, олон нийтийг танилцах боломжийг хангах;	Жилдээ	Мэдээлэл технологийн алба
2	Авлигатай тэмцэх газар болон Эрчим хүчний яамнаас Авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд оролцох а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;	-Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулж тайланд нотломжийг хавсаргасан байх; -Цахим хуудас, сошиал сувгуудад тус бүр мэдээллийг оруулсан байх;	Жилдээ	Мэдээлэл технологийн алба, эрх бүхий албан тушаалтан
	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн бус	Бизнесийн ёс зүй Комплаенсыг нэвтрүүлэх сургалт, зөвлөгөө авч		

3	байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангах, хамтран ажиллах;	бусад холбогдох чиглэлээр хамтран ажиллах;	Жилдээ	Захиргаа хүний нөөцийн хэлтэс
4	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилах;	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах;	Жилдээ	Захиргаа хүний нөөцийн хэлтэс
5	Компанийн хэмжээнд зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөг болон томоохон хэрэглэгчтэй хийх уулзалтаар авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах;	Хэрэглэгчийн уулзалт, өдөрлөг зохион байгуулахад Авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй, авлигын эсрэг оролцоотой, зөв, шударга байдлыг уриалсан сурталчилгааг зохион байгуулах;	Жилдээ	ХҮАБХ-ийн хэлтэс, эрх бүхий албан тушаалтан
6	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлига албан тушаалын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах, АТГ-аас зохион байгуулах сургалтад хамтруулах;	Авлигатай тэмцэх газар бусад эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад албан тушаалтнуудыг хамруулсан байх;	Жилдээ	Эрх бүхий албан тушаалтан
7	Компани, харьяа салбарын авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг шинэчлэн байршуулах;	компани, салбаруудын мэдээллийн самбарыг тогтмол мэдээллийг шинэчлэх, сонирхсон этгээдийг мэдээлэл авах боломжоор хангах;	Жилдээ	Эрх бүхий албан тушаалтан
8	АТГ-аас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	АТГ болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд тайлагнах;	Жилдээ	Захиргаа хүний нөөцийн хэлтэс
9	Шинээр компанийн удирдах болон эрх бүхий албан тушаалд томилогдож буй албан тушаалтнуудад ажлын байрны анхан шатны зааварчилгаа өгөхдөө авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд холбогдох хуулийг	Шинээр ажилд томилогдсон ажилтнуудад зааварчилгааг холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллах талаарх зааварчилгааг өгөх;	Жилдээ	Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс

	хэрэгжүүлж ажиллах талаар зааварчилгаа өгч ажилд оруулах;			
10	Компанийн дотоод хяналт шалгалтын механизмыг сайжруулж, албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах;	Компанийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулахдаа авлига ашиг сонирхлын зөрчилд өртөж болзошгүй болон ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж тайлагнах;	Жилдээ	Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс
11	Компанийн ажилтнуудад ёс зүйн болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;	Холбогдох сургалтыг зохион байгуулсан байх;	Жилдээ	Захиргаа хүний нөөцийн хэлтэс, компанийн ёс зүйн дэд хороо